

ТӨРДӨӨ, ХИЛЧИДДЭЭ,
ХИЛ ХАМГААЛАХ
БАЙГУУЛЛАГАДАА ТУСАЛНА



Өнгөрсөн онд **"Монголын хил хамгаалалтад туслах холбоо"** нэртэй төрийн бус байгууллага байгуулагдаж хууль зүйн яаманд бүртгүүлээд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус холбооны тэргүүн улсын хилийн түүх судлаач, магистр хурандаа Ч.Алтангэрэлтэй манай сурвалжлагчийн хийсэн ярилцлагыг нийтэлж байна.

Сурв: - Та монголын хил хамгаалалтад туслах холбоо байгуулж тэргүүнээр нь сонгогдоод ажиллаж байна. Холбоо байгуулах болсон шалтгаан, холбооныхоо зорилгын талаар танилцуулахгүй юу ?

Ч.Алтангэрэл: Монголын хил хамгаалалтад туслах холбооны эрхэм зорилго нь улсын хил хамгаалалтад бүх талаар тусалж хил хамгаалалтыг бэхжүүлэхэд оршиж байна. Улсын хилийн хамгаалалтад туслах шаардлага их өсч байна л даа. 70 орчим жил бид өмнөд хилээ манаж ирсэн. Гэтэл эдүгээ өмнөд хойд хилээ адилхан манах хэрэгтэй боллоо. Цагийн байдал хүнд байх үед хил манахад арай хялбар байлаа. Яагаад гэвэл төр засаг ард түмэн бүхий л анхаарлаа хил рүүгээ төвлөрүүлж бололцоотой бүх арга хэмжээг авснаар хил хамгаалагчид зэвсэг техник, хоол хүнс, хувцас уналга хэрэгслээр дутагддаггүй юм билээ.

Хилд хамгийн шилдэг хүмүүсээ илгээж хил манагчдын сонор сэрэмж, сахилга хариуцлага тэдний өөрийгөө хамгаалах зөн билэг нь давамгайлж байдаг. Төрөөс улсын хил орчимд тусгай арга хэмжээ авч иргэдийн амьдрах хөдөлмөрлөх орчныг зохицуулахад хүрдэг.

Хил хамгаалагчдын эрх нь нэлээд өсч үүргээ онцгой байдалд хэрэгжүүлснээр цаг үетэйгээ зохицож байдаг.

Гэтэл гадны илэрхий аюул заналхийлэлгүй, сайн хөршийн найрсаг харьцаатай орнуудтай хиллэсэн харьцангуй тайван нөхцөлд улсын хил дээр гарсан зөрчил нь хил хамгаалагчдад онцгой хүндрэл

учруулж байна.

Төрийн зүгээс хилийн зөрчлийг анхаарч хайхардаггүйгээс иргэдээс хил зөрчихийг ч юман чинээнд боддоггүй болчихдог аж. Хил хамгаалагчдын сонор сэрэмж суларч хил хамгаалалтын улс төрийн ач холбогдол буурдаг сөрөг нөлөө харагдаж байна. Хил манах алба нь тайван цагийн байлдааны үүрэг байхаа болихын зэрэгцээ үнэлэмж нь нийгмийн сэтгэл зүйгээ даган багасаж байна.

Ийм учраас хил манахын улс төр, эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг олон талаас нь тайлбарлаж төр, ард түмэндээ ойлгуулах учиртай. Энэ үүргийг дан ганц төрийн зүгээс хийж дийлэхгүй байна. Төрдөө, хил хамгаалагчиддаа, хил хамгаалах байгууллагадаа туслахын тулд монголын иргэд үүрэг хүлээх ёстой. Тэр л үүргийг бид хэрэгжүүлэх гэж холбоо байгуулсан юм. Манай холбоо нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага бөгөөд санаачлагч дэмжигчдийнхээ хүч туслалцаанд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Сурв: - *Та төрийн тусгай албаны албан хаагч хүн. Энэ холбоог байгуулж, тэргүүнээр нь сонгогдож ажиллахад хууль зөрчигдөх асуудал бий юу?*

Ч.Алтангэрэл: - Ийм зүйл огт байхгүй. Хуулийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа юм. Бидэнд аль нэгэн байгууллага, тодорхой албан тушаалтнуудтай сөргөлдөх эрх мэдэл, албан тушаал булаацалдах сонирхол байхгүй. Энэ бидний зам биш. Бидний үйл ажиллагаагаа явуулах арга зам бол улсын хилээ гэсэн зүрх сэтгэлтэй бүхий л хүмүүс байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулах явдал юм. Манай холбоо нь "Төрийн бус байгууллагын тухай" Монгол Улсын хууль, Холбооныхоо дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

Улсын хил, түүний хамгаалалтын талаар төр засгаас боловсруулсан ба боловсруулж байгаа бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээг зөв чиг баримжаатай явуулахын төлөө ажиллаж байна.

Үзэл баримтлалын гэмээр зарим алдааг засахын тулд хуулийн хүрээнд холбогдох субъектүүд нь мэдэгдэл саналаа хүргүүлж байгаа юм. Манай холбоо улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох талаар саналаа боловсруулж удирдлагуудад хүргүүлж байна.

Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ч ашиглаж өөрсдийн санал дүгнэлтийг уншигч олонтойгоо хуваалцаж байгаа. Улс нийгмийн эрх ашигт нийцээгүй аливаа асуудлыг таслан зогсоох талаар хуулийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах бололцоо ч бий.

Улсын хилийн зөрчлийг одоогийн хуулиар зөвхөн хилийн шугамын зөрчил хэмээн ойлгон дэндүү явцуу томьёолсон нь цаг

үетэйгээ тохирохгүй байна. Улсын хилийн асуудалд үндэсний аюулгүй байдал талаасаа илүү анхааран хандах шаардлагатай юм.

Сурв: - Улсын хилийн улс төр, эдийн засгийн ач холбогдол буурч байгааг Та юу гэж тайбарлах вэ ?

Ч.Алтангэрэл: - Монгол Улсын хүн амын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээс эхлээд үйлдвэрийн бүх техник, тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүн, түүх соёлын дурсгалт зүйлс бүгд л улсын хилээр орж гарч байна.

Ихэнх нь хуулийн хүрээнд нэвтрэх боловч улсын эдийн засаг, аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц зарим зүйлийг хууль бус, нууцдалд аргаар эрх мэдэл бүхий хүмүүсийн ороцоотой нэвтрүүлдэг боллоо.

Хилээр нэвтэрч байгаа хүн, тээврийн хэрэгсэл, амьтан, ургамал, бараа товаарыг маш олон байгууллагууд шалгаж хянаж байна. Хил дээрх хяналт, шалгалтын эдгээр байгуулагад нэгдсэн удирдлага зохион байгуулалт алга. Тус тусдаа эрх дархтай байх гэсэн санаархал нь тэднийг алдаанд хүргэж байна. Улсын хилээр орж ирж байгаа бараа ялангуяа хүнсний бүтээгдэхүүн ямар ч шинжилгээгүй байдаг.

Улсын хилээр орж гарч байгаа бараанаас зохих татвараа авч чадахгүй байна. Улсад орох ёстой татвар зарим нэг гаальчдын "шан" болж амьдралыг нь өөд татаад л өнгөрч байна шүү дээ.

Боомт бус газраар зарим нэгэн хилчдийн шууд оролцоотой улсын эдийн засагт чухал байр эзэлдэг ноолуур мэтийн үнэт түүхий эд гадагш гарч, гэмт хэргийн үндсийн үндэс болсон, нэг хүнийг байтугай, бүхэл бүтэн улс үндэстнийг бусниулж буй спирт гэгч "хар өнгийн хар мөрт" чимээгүй устгагч "аюулт бөмбөг" шуналт хүмүүсийн хорыг буцалган өврийг түнтийлгэхээр орж ирсээр байна.

Улсын хил дээр хяналт, шалгалт нэг гарт төвлөрөөгүйн улмаас хил ингэж бизнесийн хэрэглүүр болж байгаа юм. Иймд улсын хилийг манаж, бүх хяналт шалгалтыг хийж, зохих арга хэмжээг нь авч чаддаг тийм эрх бүхий байгууллага үгүйлэгдэж байна гэсэн үг.

Эдгээрээс л болж улсын хилийн улс төр, эдийн засгийн ач холбогдол илэрхий буурч байна.

Сурв: - Чухам ямар арга хэмжээ авч байж энэ байдлыг өөрчлөх вэ ?
Ч.Алтангэрэл: - Засгийн газрын бүтцэд ордог "Улсын хил хяналтын хороо" байгуулж хилийн бүхий л асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хил хамгаалагчид, тэдний гэр бүл, үр хүүхдүүд нь ямар нэгэн

байдлаар нийгмийн хамгааллаар дутаж боловсрол соёлоор хоцорч, нэг үгээр хөдөө хөхөрч, гадаа гандан хохирч байгаа юм.

Тэдний амьдралыг төр мэддэг гэхэд ч мэддэггүй гэхэд ч хэцүү байна. Холбогдох хүмүүст нь дуу хоолойгоо хүргэж байдлаа ойлгуулах арга механизм ч байхгүй байна.

Хил орчмын иргэдийн амьдрал доройтож, аюулгүй байдал нь алдагдаж нутаг бэлчээр эзгүйрэх боллоо. Үүний буруутан нь иргэд биш гагцхүү төр, түүний зөв бодлого дутаж байгаагаас дээрх аюул нүүрлэж байна.

Улсын хил гэдэг нь хоёр улсыг заагласан шугам боловч айл гэрийн хаяа, хана нь юм. Айл бүхэн хаяагаа манаж болзошгүй аюулаас сэргийлдэгийн нэг адил Монгол Улс хилээ хүч бололцоогоороо хамгаалж ирсэн. Гэхдээ өөр дээрээ гал дуудаж, үндэсний эрх ашиг, аюулгүй байдалдаа хохирол учруулахаас ямагт болгоомжлон сэрэмжлэн сэргийлэх учиртай.

Гэтэл улсын хилээ хамгаалж буй өнөөгийн тогтолцоо онолын ч, практикийн ч хувьд алдаатайгаар барахгүй аюултай юм. Яг л галаар тоглож байгаатай адил улсын хилийг "фронтын шугам" болгож байна шүү дээ.

Хоёр их гүрний дунд оршдог цэрэг, эдийн засгийн хүч чадал багатай манай орны хувьд байлдах зориулалт бүхий зэвсэгт хүчнийхээ цэргийг улсынхаа хилээс холхон байлгаж их хөршүүддээ үлгэр үзүүлэхийн зэрэгцээ тэдний цэргийг ч хилээс нь холдуулах дипломат бодлого явуулах шаардлагатай байгаа юм. Зэвсэгт хүчин, БХЯ-даа харьяалагддаггүй зөвхөн хил хамгаалах үүрэг бүхий буудлагын зэвсэгтэй цэргийг л хил дээрээ байлгаж хилээ мануулах талаар ч хөршүүдтэйгээ тохиролцож болох юм.

Улсын хилийг өнөөгийн нөхцөлд заавал цэрэг биш цэрэгжүүлсэн байгууллагаар ч мануулж, шалгаж, хянуулахад болохгүй зүйлгүй. Аль ч тохиолдолд хязгаар нутгийн хил орчмын иргэдийн хүчинд тулгуурласнаар асуудлыг шийдэж чадна.

Магадгүй улсын хил хамгаалалтыг санаатай болон санамсаргүй сулруулсан, сулруулахыг санаархагчдад хариуцлага хүлээлгэх цаг нь болсон байж ч мэднэ. Тийм хүмүүст дашрамд нь анхааруулмаар байна.

Сурв: - Танд баярлалаа. Танай холбооны ажилд өндөр амжилт хүсье.

Ярилцсан Г.Дагважамц